

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Наранбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/14/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2023 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Авирмэд Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.24 № УВА-2023/14/НА-СТА-ТЦЗ
танай _____-ны № _____-т

НАРАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
А.МӨНГӨНЦЭЦЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Наранбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Наранбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Наранбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж 7,740.0 мянган төгрөгийн 3 гүйлгээг хийсэн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

E:/sta-2023/A4-blank.docx

0200200410

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	13
4. Аудитын тайлан.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. Аудитын илрүүлэлт	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,274,620.00	2,458,820.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,274,620.00	2,458,820.00
354	Хангамжийн материал	2,274,620.00	2,458,820.00
35410	Бичиг хэргийн материал	338,800.00	203,000.00
35420	Аж ахуйн материал	1,935,820.00	2,255,820.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,335,499.65	5,568,332.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,335,499.65	5,568,332.93
392	Биет хөрөнгө	3,335,499.65	5,568,332.93
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	14,745,000.00	18,425,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,120,000.08	-14,839,166.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,158,480.00	10,158,480.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,447,980.27	-8,175,980.31
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,610,119.65	8,027,152.93
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,610,119.65	8,027,152.93
51	Засгийн газрын хувь оролцоо	5,610,119.65	8,027,152.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		26,650,540.00	26,650,540.00
51101	Өмч: - төрийн	26,650,540.00	26,650,540.00
512	Хуримтлагдсан үр дүн	-21,075,448.35	-18,658,415.07
51210	Өмнөх үеийн үр дүн	-21,075,448.35	-21,075,448.35
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,417,033.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	35,028.00	35,028.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,610,119.65	8,027,152.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	65,193,500.00	83,744,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,193,500.00	83,744,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	815,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	815,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	64,378,500.00	83,744,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	64,378,500.00	83,744,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	66,260,033.07	81,327,166.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	66,260,033.07	81,327,166.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,077,337.04	67,931,475.72

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,606,794.00	47,379,619.35
210101	Үндсэн цалин	31,564,394.00	30,679,062.77
210102	Нэмэгдэл	00.00	5,650,793.58
210104	Урамшуулал	10,042,400.00	11,049,763.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,157,209.97	5,864,589.65
210201	Тэтгэврийн даатгал	3,731,151.80	4,026,945.68
210202	Тэтгэмжийн даатгал	416,271.27	473,796.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	313,997.81	379,036.95
210204	Ажилгүйдлийн даатгал	55,863.39	87,431.25
210205	Эрүүл мэндийн даатгал	639,925.70	897,379.58
2104	Хангамж, бараа материалын зардал	4,771,500.00	5,725,000.00
210401	Бичиг хэрэг	463,500.00	684,600.00
210402	Тээвэр, шатахуун	4,033,000.00	4,540,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,000.00	500,000.00
210408	Бараа материал ақталсны зардал	25,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	75,000.00	82,000.00
210604	Урсгал засвар	75,000.00	82,000.00
2107	Томилолт, зочны зардал	583,000.00	1,060,000.00
210702	Дотоод албан томилолт	583,000.00	1,060,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	412,400.00	365,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	193,400.00	275,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.00	90,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	75,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,471,433.07	7,454,666.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,246,600.00	4,174,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,147,500.00	1,833,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,077,333.07	1,447,166.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,182,696.03	13,395,691.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	959,400.00	13,147,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	959,400.00	13,147,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,223,296.03	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,223,296.03	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	248,691.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	248,691.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-1,066,533.07</u>	<u>2,417,033.28</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-1,066,533.07</u>	<u>2,417,033.28</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	65,193,500.00	83,744,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,193,500.00	83,744,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	815,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	815,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	64,378,500.00	83,744,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	64,378,500.00	83,744,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	65,193,500.00	83,744,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,193,500.00	83,744,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,010,803.97	70,348,509.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,606,802.00	47,317,809.00
210101	Үндсэн цалин	31,564,402.00	30,617,412.42
210102	Нэмэгдэл	00.00	5,650,793.58
210104	Урамшуулал	10,042,400.00	11,049,603.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,157,201.97	5,926,400.00
210201	Тэтгэврийн даатгал	3,731,151.80	4,030,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	416,271.27	474,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	313,997.81	379,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	55,863.39	94,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	639,917.70	948,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,782,300.00	5,589,200.00
210401	Бичиг хэрэг	499,300.00	548,800.00
210402	Тээвэр, шатахуун	4,033,000.00	4,540,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	75,000.00	4,082,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	75,000.00	82,000.00
2107	Томилолт, зочны зардал	583,000.00	1,060,000.00
210702	Дотоод албан томилолт	583,000.00	1,060,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	412,400.00	365,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	193,400.00	275,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.00	90,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	75,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,394,100.00	6,007,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,246,600.00	4,174,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,147,500.00	1,833,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,182,696.03	13,395,691.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	959,400.00	13,147,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	959,400.00	13,147,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,223,296.03	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,223,296.03	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	248,691.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	248,691.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	26,650,540.00	81,438.00	-4,639,155.64	22,092,822.36
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	46,410.00	46,410.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,650,540.00	81,438.00	-4,592,745.64	22,139,232.36
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-46,410.00	00.00	-46,410.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,104,993.77	-1,104,993.77
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,650,540.00	35,028.00	-21,075,448.35	5,610,119.65
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	26,650,540.00	35,028.00	-21,075,448.35	5,610,119.65
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,650,540.00	35,028.00	-21,075,448.35	5,610,119.65
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,417,033.28	2,417,033.28
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,650,540.00	35,028.00	-18,658,415.07	8,027,152.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	83,744,200.00	83,495,509.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	83,744,200.00	83,495,509.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,577,600.00	70,348,509.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,411,700.00	47,317,809.00
210101	Үндсэн цалин	37,369,300.00	30,617,412.42
210102	Нэмэгдэл	00.00	5,650,793.58
210104	Урамшуулал	10,042,400.00	11,049,603.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,926,400.00	5,926,400.00
210201	Тэтгэврийн даатгал	4,030,000.00	4,030,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	474,100.00	474,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	379,300.00	379,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	94,800.00	94,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	948,200.00	948,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,597,200.00	5,589,200.00
210401	Бичиг хэрэг	549,900.00	548,800.00
210402	Тээвэр, шатахуун	4,540,400.00	4,540,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	506,900.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,086,700.00	4,082,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	86,700.00	82,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,060,200.00	1,060,000.00
210702	Дотоод албан томилолт	1,060,200.00	1,060,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	365,600.00	365,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	275,600.00	275,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	90,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6129800.00	6007500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,296,800.00	4,174,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,833,000.00	1,833,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13166600.00	13147000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,166,600.00	13,147,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,166,600.00	13,147,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	83,744,200.00	83,495,509.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	83,744,200.00	83,495,509.00
132001	Орон нутгийн төсвөөс	83,744,200.00	83,495,509.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	06.00	06.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	01.00	01.00
620004	Гэрээт ажилтан	04.00	04.00

3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Наранбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бие даан зохион байгуулах гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Наранбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузел сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Наранбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Наранбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,232.9 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	2,274.6	2,458.8	184.2
Үндсэн хөрөнгө	3,335.4	5,568.3	2,232.9
Нийт хөрөнгө	5,610.1	8,027.1	2,417.0
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,610.1	8,027.1	2,417.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,610.1	8,027.1	2,417.0

Бараа материалын дансны үлдэгдэл 2,458.8 мянган төгрөг болж 184.2 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,568.3 мянган төгрөг болж 2,232.9 мянган төгрөгөөр өссөн нь машин тоног төхөөрөмжийн худалдан авснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,027.1 мянган төгрөг болж 2,417.0 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө, бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 82,511.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 82,511.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,232.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 83,744.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 83,744.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 83,744.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 83,744.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 83,495.5 мянган төгрөгийг зарцуулж, 248.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 83,495.5 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь зардлыг 248.7 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70105: Үндсэн үйл ажиллагааны зардал-80101	54,789.8	54,683.0	106.8	99.8%
	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70105: Мэдээлэл сурталчилгааны зардал- 80205	193.4	193.4	0	100%
	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70105: Ажил олгогчоос олгох тэтгэмж-80802	13,166.6	13,147.0	19.6	99.9%
	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70105: Багийн ИНХ-ын даргын урамшуулал-80825	11,297.6	11,297.6	0	100%
	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70105: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх-82201	4,296.8	4,174.5	122.3	97.2%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Наранбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Наранбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 1.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 81.3 сая төгрөгийн 2.0 хувь буюу 1.6 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 1.3 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Сагил сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 139, хугацаа хоцроож байршуулсан 10, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Наранбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	360.0	1	360.0	100
Зөвлөмж					
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,016.3 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрсэнд 2 зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Наранбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж 7,740.0 мянган төгрөгийн 3 гүйлгээг хийсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус мөрдөж ажиллах ажиллах.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын 2022 оны А/17 дугаар тушаалаар нягтлан бодогчийн ажил хавсран гүйцэтгэдэг О.Ганчимэгт улирлын ажлын үр дүнгийн урамшуулал 1,276.3 мянган төгрөг олгосон байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.2 дахь заалтад “төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн **гүйцэтгэлийн үнэлгээ**, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгоно” гэж заасныг мөрдөж ажиллах ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн эдийн засгийн ангилал зөрчсөн, ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоол зөрчиж урамшуулал өгсөн.	2	9,016.3					2	9,016.3				
Дүн	2	9,016.3					2	9,016.3				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархан илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /Б.АВИРМЭД/

2023 оны 02 сарын 17-ны өдөр